



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар Б/43

Баян-Овоо сум


**Мэргэжлийн зэргийн нэмэгдэл
олгох тухай**

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2013 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт (төрийн үйлчилгээний албан хаагчдад мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам), Боловсролын сайдын 2024 оны А/95 дугаар тушаал (журам шинэчлэн батлах тухай)-ыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Тэргүүлэх, заах аргач" мэргэжлийн зэргийн шалгуурыг хангаж бататгах болон хуучин багш нарын нэрсийг нэгдүгээр хавсралтаар, мэргэжлийн зэргийг шинээр авах багш нарын нэрсийг хоёрдугаар хавсралтаар батласугай.

2. Шинээр тэргүүлэх болон заах аргач мэргэжлийн зэрэг авах багш нарын нэмэгдлийг тооцож, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д үүрэг болгосугай.

3. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сургалтын менежер (П.Болортуяа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ  Ч.БОЛОРМАА

